



2026 оны 03 сарын 04 өдөр

№ 26/02

Монгол улс

**ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ  
ХУРАЛ ХУРАЛДУУЛАХ ТУХАЙ**

Компанийн тухай хуулийн 59 дүгээр зүйлийн 59.4, 60 дугаар зүйлийн 60.1, 60.2, 60.4, 76 дугаар зүйлийн 76.1.2 дахь заалт, Санхүүгийн зохицуулах хорооны 2018 оны 12 дугаар сарын 14-ний 377 дугаар тогтоолоор батлагдсан “Хувьцаат компанийн хувьцаа эзэмшигчдийн хурлын зар хүргэх журам”, “Дархан Хүнс” ХК-ийн дүрэм 6.3 дугаар зүйлийн 6.3.1, 6.3.4 болон 6.3.7 дах хэсгийг тус тус үндэслэн **ТОГТООХ нь:**

1. “Дархан Хүнс” ХК-ийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлыг 2026 оны 04 дүгээр сарын 13-ний өдрийн 14<sup>00</sup> цагт Дархан-Уул аймаг, Дархан сум 5 дугаар баг, Ардын өргөн чөлөө-8, 807 хаягт байрлах “Дархан Хүнс” ХК-ний хурлын танхимд хуралдуулсугай.
2. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлыг зарлах тухай мэдэгдлийг 2026 оны 03 дугаар сарын 09-ний өдрийн дотор Санхүүгийн зохицуулах хороо болон Монголын хөрөнгийн биржид тус тус хүргүүлэхийг Төлөөлөн удирдах зөвлөлийн нарийн бичгийн дарга (Д.Мөнхцэцэг)-т даалгасугай.
3. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын зарыг Монголын хөрөнгийн биржийн цахим хуудсаар болон өдөр тутмын хоёроос доошгүй сонин, бусад хэвлэл мэдээллийн хэрэгслээр дамжуулан 2026 оны 03 дугаар сарын 09 өдөр олон нийтэд мэдээлж, уг зарын давталтыг 2026 оны 03 дүгээр сарын 24 - ний өдөр анх зарласан хэлбэрээр дахин нийтэд мэдээлэхийг Гүйцэтгэх захирал (Г.Нямдалай)-д даалгасугай.
4. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хуралд оролцох эрхтэй хувьцаа эзэмшигчдийн нэрсийн жагсаалт гаргах бүртгэлийн өдрийг 2026 оны 3 дугаар сарын 27-ний өдрөөр тогтоосугай.
5. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаар хэлэлцэх асуудалтай холбоотой гаргах шийдвэрийн төсөл, танилцуулга, саналын хуудас зэрэг хувьцаа эзэмшигчдийн ээлжит хуралтай холбогдох бусад баримт бичгийг 2026 оны 3 дугаар сарын 14-ний өдөрт багтаан үнэт цаасны брокер дилерийн компанид хүргүүлэхийг Гүйцэтгэх захирал (Г.Нямдалай)-д даалгасугай.

6. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаар хэлэлцэх асуудлын жагсаалтыг нэгдүгээр хавсралт, хурлын зарын загварыг хоёрдугаар хавсралт, хурлаар хэлэлцэх асуудалтай холбоотой материалын жагсаалтыг гуравдугаар хавсралт, саналын хуудасны загварыг дөрөвдүгээр хавсралтаар тус тус баталсугай.
7. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурал зохион байгуулах комиссыг тавдугаар хавсралт, хурлын тогтоолын комиссыг зургаадугаар хавсралтад заасан бүрэлдэхүүнтэйгээр тус тус байгуулсугай.
8. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын материалтай танилцах боломжийг хувьцаа эзэмшигч бүрд олгох нөхцөлийг бүрдүүлж ажиллахыг Гүйцэтгэх захирал (Г.Нямдалай)-д даалгасугай.
9. Хувьцаа эзэмшигчдийн саналыг урьдчилсан байдлаар 2026 оны 4 дүгээр сарын 8-ны өдрийн 17:30 цаг хүртэл хугацаанд брокер, дилерийн компаниар дамжуулан эсхүл “Дархан Хүнс” ХК-ийн байранд цаасан болон цахим хэлбэрээр [info@darkhankhuns.mn](mailto:info@darkhankhuns.mn) урьдчилан авах боломжийг бүрдүүлж ажиллахыг хурал зохион байгуулах комисс (Г.Нямдалай)-д даалгасугай.
10. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хуралд оролцсон хувьцаа эзэмшигчдийн саналын хуудсыг цаасан болон цахим хэлбэрээр авч, нэгдсэн тооллогын үр дүнг хувьцаа эзэмшигчдийн хуралд танилцуулж шийдвэрлүүлэхийг тооллогын комисс (Г.Нямдалай)-д даалгасугай.
11. Хувьцаа эзэмшигчдийн хурлын даргаар Төлөөлөн удирдах зөвлөлийн дарга (Д.Бат-Эрдэнэ)-ыг томилсугай.
12. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаар шийдвэрлэсэн асуудал болон бусад шаардлагатай материалыг Компанийн тухай хууль, Үнэт цаасны зах зээлийн тухай хууль, холбогдох бусад журамд заасан хугацаанд Монголын хөрөнгийн бирж, Санхүүгийн зохицуулах хороонд хүргүүлэхийг Төлөөлөн удирдах зөвлөлийн нарийн бичиг (Д.Мөнхцэцэг)-т даалгасугай.

**ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ  
ЗӨВЛӨЛИЙН ДАРГА**



**Д.БАТ-ЭРДЭНЭ**

Дархан уул аймаг, Дархан сум, 5-р баг

утас: 99112500